МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 08 өдөр Дугаар А/101 Улаанбаатар хот

## Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 15.1.4.г. дэх заалт, "Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах хорооноос ирүүлсэн зөвлөмжийг 2024-2026 онд хэрэгжүүлэх салбар дундын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Салбар дундын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхийг Ажлын хэсгийн гишүүдэд даалгасугай.

3. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчилах үзлийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн Засгийн газрын ээлжит 11 дүгээр тайланг бэлтгэн, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтсон хугацаанд конвенцын хороонд хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч /С.Зулпхар/-д даалгасугай.

Х.БУЛГАНТУЯА

151240309

D: 2024 on 05 sar tushaal

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн
А/101 дугаар тушаалын хавсралт

# НҮБ-ЫН "ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ АЛАГЧИЛАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ" КОНВЕНЦЫН ЗӨВЛӨМЖИЙГ 2024-2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Зөвлөмж/ зөвлөмжийн дугаар | № | Хэрэгжүүлэх арга хэмжээ, арга хэмжээний дугаар | Шалгуур үзүүлэлт | Хариуцах байгууллага | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хариуцан хэрэгжүүлэх | Хамтран хэрэгжүүлэх |
| **Нэг. Цар тахал болон сэргэлтийн үйл ажиллагаатай холбоотой эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал** | | | | | | |
| 1. | 9(a) Урт хугацаандтогтсон эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын тэгш бус байдлыг арилгахын тулд институци, хууль тогтоомж, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх. Тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдуулан, Ковид-19-ийн дараах сэргэлтийн стратеги бодлогод эмэгтэйчүүдийн талаарх асуудлыг тусгах замаар жендэрийн тэгш байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх. | 1. | (ТХЗ 5c) Бүх түвшинд жендерийн тэгш байдлыг хөхүүлэн дэмжих, охид, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зохистой бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх. | Жендерийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан төсөв /сая.төг/ | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Жендэрийн салбар зөвлөл, хороод |
| 2. | 9(b) Хямралын дараах сэргэлтийн төлөвлөгөөний хүрээнд охид эмэгтэйчүүд, үүргийг жендерийн хэвшмэл байдлаар харж ухрахгүй байхыг баталгаажуулах. | 2. | (ТХЗ 5.1) Бүх эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох арга хэмжээ хэрэгжүүлэх. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Хууль зүй, дотоод хэргийн яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба |
| 3. | 9(c) "Ковид-19"-ийн дараах сэргэлтийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд эмэгтэйчүүд, охид, ялангуяа ядуу болон гадуурхагдсан бүлгийн эмэгтэйчүүдийн тэгш оролцоог хангах. | 3. | (ТХЗ 8.5) Ядуу, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох. | Ажилгүйдлийн түвшин болон дундаж цалин хөлс хүйсээр, насны бүлгээр, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдээр, зорилтот бүлгээр | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Эдийн засгийн хөгжлийн яам<br>Үндэсний статистикийн хороо<br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар |
| | | 4. | Бодлого, хөтөлбөр боловсруулахдаа ядуу, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй | Хөгжлийн бодлого, арга хэмжээ боловсруулахад оролцсон ядуу, эмзэг бүлгийн эмэгтэйчүүд болон хөгжлийн | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эмэгтэйчүүдийн оролцоог хангах. | бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тоо | | |
| 4. | 9(d) Цар тахлын нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад чиглэсэн үнэ хөлсгүй халамжлах ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг урамшууллын багцаас эмэгтэйчүүд, охид тэгш хүртэхийг баталгаажуулах. | 5. | (ТХЗ 5.4) Өрх, гэр бүлийн дотор үүрэг хариуцлагаа хуваалцах явдлыг хөхүүлэн дэмжих замаар цалин хөлсгүйгээр хүн асрах, гэрийн ажил хийх явдлыг хүлээн зөвшөөрч, түүний ач холбогдлыг эрхэмлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх. | Гэрийн болон асран халамжлах үнэ төлбөргүй хөдөлмөрт зарцуулсан цагийн эзлэх хувь, хүйс, нас, байршлаар | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба |
| **Хоёр. Конвенцын хэрэгжилтийн бодит байдал** | | | | | | |
| 5. | 11(a) Төрийн албан хаагчид, шүүгч, прокурор, цагдаа болон хууль сахиулах байгууллагын бусад албан тушаалтан, хуульчдыг конвенцын талаар системтэйгээр чадавхжуулж, сургалтад хамруулах. | 6. | Төрийн албан хаагч, шүүгч, прокурор, цагдаагийн алба хаагчдад конвенцын зарчим, агуулга, хэрэгжилтийн асуудлаар шаталсан сургалт зохион байгуулах. | Конвенцыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалтад хамрагдсан хууль хэрэгжүүлэх байгууллагын албан хаагчийн тоо | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв<br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн<br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба |
| 6. | 11(b) Конвенцод заасан эмэгтэйчүүдийн эрхийнх нь талаарх ойлголтыг нэмэгдүүлж, эдгээр эрх зөрчигдсөнийг нэхэмжлэх хууль зүйн арга замуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, конвенц болон Хорооны ерөнхий зөвлөмжийн тухай мэдээллийг бүх эмэгтэйчүүдэд, ялангуяа ядуу болон гадуурхагдсан бүлэгт хамаарах, хөдөөгийн болон малчин эмэгтэйчүүд, лесби, бисексуал, трансжендер, интерсекс эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгах. | 7. | Конвенцод заасан эмэгтэйчүүдийн эрхийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, зөрчигдсөн тохиолдолд хэрхэн нэхэмжлэх тухай зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд зориулсан энгийн ойлгомжтой мэдээлэл, сурталчилгааны материал боловсруулан иргэний нийгмийн байгууллагаар дамжуулан хүргэх. | Конвенцын талаарх мэдээлэл хүргэсэн эмэгтэйчүүдийн тоо | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7. | 13(a) Эмэгтэйчүүдийг алагчлах, тэр дундаа төрийн болон хувийн хэвшилд шууд болон шууд бусаар алагчлах, түүнчлэн бэлгийн чиг баримжаа болон жендерээр алагчилж нэр хоч өгөх гэх мэт алагчлалын холимог хэлбэрийг хориглосон алагчлахын эсрэг хууль тогтоомжийг цаг алдалгүй батлах. | 8. | Төрийн болон хувийн хэвшилд эмэгтэйчүүдийг алагчлахыг хориглох хууль, эрх зүйн зохицуулалт шаардлагатай эсэхэд тандах судалгаа хийх, судалгааны үр дүнд үндэслэн эрх зүйн өөрчлөлт, шинэчлэл хийх. | Тандалтын судалгааны тайлан, үр дүнгийн дагуу боловсруулан шийдвэрлүүлсэн баримт бичиг | Хууль зүй, дотоод хэргийн яам | Хууль зүйн үндэсний хүрээлэн |
| 8. | 13(b) Алагчлалын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, тогтмол хяналт тавих, нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах төсвийг хангалттай хуваарилах. | 9. | Алагчлалын эсрэг заалт агуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, нөлөөллийн үнэлгээ хийхэд шаардагдах төсвийг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг олон нийтэд мэдээлдэг байх. | Үнэлгээний тайлан, зарцуулсан төсөв, олон нийтийн мэдээллийн тоо | Хууль зүй, дотоод хэргийн яам | Сангийн яам<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба |
| 9. | 13(c) Шүүгч, прокурор, хуульч, цагдаагийн алба хаагч эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангах, тэр дундаа эмэгтэйчүүдийн эсрэг алагчлалыг тодорхойлох, алагчлалыг гэмт хэрэгт тооцох чадавхыг бүрдүүлэх.<br>22(d) Жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх бий болгох явдлыг судлах. | 10. | Шүүгч, прокурор, хуульч, цагдаагийн алба хаагч эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан хууль сахиулах байгууллагын албан хаагчийн тоо, хүйсээр | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба<br>Цагдаагийн ерөнхий газар<br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв<br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн |
| 10. | 13(d) Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоотойгоор эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг алагчлах явдлыг тодорхойлох, гэмт хэрэгт тооцох талаар иж бүрэн боловсрол олгох, ойлголт нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг дэмжих. | 11. | Эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг алагчлах явдлыг тодорхойлох, гэмт хэрэгт тооцох талаар иж бүрэн боловсрол олгох цахим сурталчилгааны материал бэлтгэж, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан түгээх. | Цахим хуудсанд мэдээллийг байршуулсан олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тоо, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын тоо | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Хууль зүй, дотоод хэргийн яам<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br>Боловсрол, шинжлэх ухааны яам<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Гурав. Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний тогтолцоо** | | | | | | |
| 11. | 15(a) Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хуулийг бүх түвшинд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дайчилж, шаардлагатай санхүүгийн эх үүсвэрээр хангах. | 12. | Жендэрийн эрх тэгш байдлыг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг салбарын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хангаж ажиллах. | ЖЭТБХ тухай хуулийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, төсөв баталсан байгууллага, аж ахуйн нэгжийн тоо, төсвийн хэмжээ | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Төрийн байгууллагууд<br>Иргэний нийгмийн байгууллага<br>Аж ахуйн нэгж, байгууллага |
| 12. | 15(b) Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах үндэсний шинэ стратегийг цаг алдалгүй баталж, тодорхой шалгуур үзүүлэлт, зорилтуудыг багтаасан үр дүнд чиглэсэн хандлагыг тусгаж, иргэний нийгмийн байгууллагуудын идэвхтэй оролцоотойгоор стратегийн үр нөлөөг үнэлэх, хяналтын механизм, нөлөөллийн үнэлгээг тогтмол хугацаанд нэвтрүүлж, хэрэгжүүлэхэд хангалттай хүний, техникийн болон санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах. | 13. | Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1-ийн хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөөний /2022-2031/ хэрэгжилтийг хангаж ажиллах. | Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтийн хувь | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Аж ахуйн нэгж, байгууллага<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| **Дөрөв. Хүний эрхийн үндэсний байгууллага** | | | | | | |
| 13. | 17(a) Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг нийслэлээс гадна хөдөө орон нутагт бодитой таниулах ажлыг нэмэгдүүлэх. | 14. | Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг орон нутагт сурталчлах зорилгоор орон нутгийн хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах. | Хамтран ажилласан орон нутгийн байгууллагын тоо, нэвтрүүлэг, мэдээллийн агуулга, тоо | Хүний эрхийн үндэсний комисс | Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 14. | 17(b) Хүний эрхийн үндэсний комиссын эрх үүргийн талаарх эмэгтэйчүүдийн мэдлэгийг дээшлүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах талаар гомдол гаргах механизмын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчлийн хохирогч болсон эмэгтэйчүүдийг гомдол гаргахыг дэмжих ажлыг эрчимжүүлэх хүчин чармайлт гаргах | 15. | Хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн танхимын болон цахим зөвлөгөө, анхан шатны мэдээлэл өгөх, зөрчигдсөн эрхийг хамгаалах ажлыг зохион байгуулах. | Танхимын болон цахим зөвлөгөөний агуулга, тоо, сургалт, зөвлөгөө, мэдээлэл авсан эмэгтэйчүүдийн тоо, эрхийг нь хамгаалсан хүний тоо, хүйсээр | Хүний эрхийн үндэсний комисс | Жендэрийн бүх салбар зөвлөл, хороод<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15. | 17(c) Бие даасан байдлаа хангахад хангалттай хүн, техник, санхүүгийн эх үүсвэрийг авч байгаа эсэхийг баталгаажуулсан мэдээлэл хороонд ирүүлэх. | 16. | Хүний эрхийн Үндэсний комиссын үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээл, ололт амжилт, жендэрийн тэгш эрхийг хангах талаар тайланг бэлтгэх. | Хүний эрхийн Үндэсний комиссын тайлан | Хүний эрхийн үндэсний комисс | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| **Тав. Богино хугацааны тусгай арга хэмжээ** | | | | | | |
| 16. | 19(a) УИХ-ын болон орон нутгийн сонгуульд улс төрийн намуудын сонгуульд нэр дэвшигчдийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчд дор хаяж 40 хувь байхаар квот тогтоож, үүнийг зөрчвөл шийтгэл ногдуулах асуудлыг нэн даруй нэвтрүүлэх. | 17. | Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн тусгайлан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх. | Хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний тайлан, хэрэгжилтийн хүрээнд гарсан өөрчлөлт, 2024 оны сонгуулын үр дүнгийн тайлан | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Сонгуулийн Ерөнхий хороо |
| 17. | 19(b) Улс төрийн оролцоо болон ажил эрхлэлт гэх зэрэг эмэгтэйчүүдийн төлөөлөл бага салбарт шийдвэр гаргах болон удирдах албан тушаалд Конвенцын хүрээнд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих богино хугацааны тусгай арга хэмжээг авч, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш байдлыг бодитой хангах ахиц дэвшлийг хурдасгах зорилгоор хугацаатай зорилтыг дэвшүүлж, дагаж мөрдөөгүй тохиолдолд шийтгэлийн арга хэмжээ авахыг хамтад нь тусгах. | 18. | Өндөр мэдлэгтэй залуу эмэгтэйчүүдийг улс төрд оролцуулах, туршлагатай эмэгтэй улс төрчтэй менторшипийн холбоо тогтоох талаар УИХ-ын сонгууль бүрийн өмнө улс төрийн намуудад уриалах. | Уриалга гаргасан улс төрийн намуудын тоо, намуудын дэвшүүлсэн эмэгтэйчүүдийн тоо, сонгуулийн үр дүн | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Улс төрийн намууд, түүний дэргэдэх Эмэгтэйчүүдийн холбсод |
| **Зургаа. Хэвшмэл ойлголтууд** | | | | | | |
| 18. | 21(a) Гэр бүл, нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагаар алагчилсан хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн тусгайлсан төсөв, үр дүнд суурилсан зорилт бүхий цогц стратегийг батлах ажлыг түргэсгэх. | 19. | Гэр бүл, нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагаар алагчилсан хэвшмэл ойлголтыг багасгахад чиглэсэн стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх, нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах. | Хэрэгжүүлсэн нөлөөллийн арга хэмжээний агуулга, тоо | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | Боловсрол, шинжлэх ухааны яам<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар |
| 19. | 21(b) Гэр бүл, нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хариуцлагаар алагчилсан хэвшмэл ойлголтыг арилгахад чиглэсэн стратегийн хэрэгжилт, үйналтыг хариуцах төрийн | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагыг тодорхойлж, албажуулах, салбар хоорондын уялдааг хангах. | | | | | Хэвлэл, мэдээллийн байгууллага<br><br>Төрийн бус байгууллага |
| 20. | 21(c) Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлж, хүний эрх, жендэрийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах. | 20. | Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн ажилтныг эмэгтэйчүүд, хүний эрх, жендэрийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах. | Сургалтад хамрагдсан сэтгүүлчийн нийт сэтгүүлчид эзлэх хувь | Жендэрийн үндэсний хорооны ажлын алба | |
| **Долоо. Жендэрт суурилсан хүчирхийлэл** | | | | | | |
| 21 | 22(a) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу гэмт хэрэг үүсгэн шалгагдсан хэрэг цөөн байгааг анхаарах.<br>23(a) Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийг яллагдагчаар татах, зохих шийтгэлийг нь ногдуулах, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан шийтгэлийг чанд мөрдүүлэх.<br>30(d) Бэлгийн дарамтыг хөнгөн гэмт хэрэг гэж ангилж, түүнд ногдуулах ялын доод хэмжээ, гэмт хэрэгтнүүдэд ногдуулсан ял, шийтгэлийн тухай мэдээлэл дутмаг байна. | 21. | Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т заасны дагуу Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх.<br><br>Шүүх прокурор, өмгөөлөгч, цагдаагийн байгууллагын ажилтнуудын жендерийн мэдрэмж, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаар төлөвлөж хэрэгжүүлэх.<br><br>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон хариу арга хэмжээнд төсөв хуваарилж, зарцуулах. | Үр дагаврын үнэлгээний тайлан<br><br>Жендерийн мэдрэмж, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд хамрагдсан албан хаагчдын тоо<br><br>Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхээс урьчилан сэргийлэх чиглэлээр болон хариу арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө /сая.төг/ | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн ажлын алба | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Улсын ерөнхий прокурорын газар<br><br>Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Хууль зүйн туслалцааны төв |
| 22. | 22(b) Шүүгч, прокурор, цагдаа, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрүүл мэндийн ажилтнууд, засаг дарга нарт гэр бүлийн хүчирхийллийн олон талт хэлбэр, түүнийг шийдвэрлэх үүрэг хариуцлагын талаарх ойлголт нь хязгаарлагдмал байгааг анхаарах. | | | | | |
| 23. | 22(c) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хүрээнд олон талт үйлчилгээ үзүүлдэг ч санхүүжилт хомсдолтойн улмаас үр дүнтэй холбоогүй, үйл ажиллагаа нь хязгаарлагдмал байгаагаас гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнүүд хангалтгүй байна. | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 24. | 23(b) Эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа лесбиян, бисексуал, трансжендер, интерсекс, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд энэ гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд жендэрийн мэдрэмжтэй мөрдөн байцаалт, хянан шийдвэрлэх арга хэмжээг авах талаар албан сургалтыг шүүгч, прокурор, цагдаа, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрүүл мэндийн эмч мэргэжилтэн, Засаг дарга нарт өгөх, тэднийг чадавхжуулах, хүчирхийллийг гэмт хэрэгт тооцсон хууль тогтоомжийг чанд мөрдүүлэх. | 22. | Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч болсон тохиолдолд жендэрийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан мөрдөн байцаалт, хянан шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх чадавхыг бий болгох сургалтыг тогтмол зохион байгуулах. | Сургалтад хамрагдсан холбогдох албан хаагчдын тоо | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба | Хууль зүй, дотоод хэргийн яам<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br>Эрүүл мэндийн яам<br>Шүүхийн ерөнхий зөвлөл<br>Улсын ерөнхий прокурорын газар<br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br>Төрийн бус байгууллага байгууллага |
| 25. | 23(c) Жендерт суурилсан хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд үзүүлэх үйлчилгээ, ялангуяа сэтгэл зүйн зөвлөгөө, урт хугацааны нөхөн сэргээх хөтөлбөрийг эрэлт хэрэгцээнд нь тулгуурлан хөгжүүлэх, тэдгээрийн тогтвортой байдлыг хангахад хангалттай санхүүжилт хуваарилдаг байх. | 23. | Жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд чиглэсэн урт хугацааны нөхөн сэргээх хөтөлбөр хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх. | Урт хугацааны нөхөн сэргээх хөтөлбөрт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, зарцуулсан хөрөнгө, /сая.төг/ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Эрүүл мэндийн яам<br>Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Жендэрийн бүх салбар зөвлөл, хороод<br>Төрийн бус байгууллага байгууллага |
| 26 | 23(d) Эмэгтэйчүүдийн эсрэг жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх байгуулах. | 24. | Жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх асуудлыг дагнан хариуцсан шүүгч бий болгох ажлыг туршиж, цаашид орон нутгийн шүүхэд нэвтрүүлэх. | Жендэрт суурилсан хүчирхийллийн хэргийг хянан шийдвэрлэх асуудлыг дагнан хариуцсан шүүгчийн тоо | Хууль зүй, дотоод хэргийн яам | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| **Найм. Хүн худалдаалах ба бэлгийн мөлжлөг** | | | | | | |
| 27. | 24(a) Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд зориулагдсан санхүүгийн нөөц хязгаарлагдмал, ялангуяа ядуу амьдралтай гэр бүлийн охидыг худалдаалах гэмт хэргийн үндсэн | 25. | Эмзэг бүлгийн охид, эмэгтэйчүүдийг ялангуяа жендэрт суурилсан хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт нөлөөллийн | Сургалтад хамгагдсан эмзэг бүлгийн охидын тоо | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | шалтгааныг арилгахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, охидыг хамгаалах, нөхөн сэргээх хөтөлбөрүүд хангалтгүй байна. | | үйл ажиллагаа зохион байгуулах.<br><br>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Цагдаа, прокурор, шүүгч нарын "хохирогч төвтэй" хэрэг хянан шийдвэрлэх хандлага, арга зүйд сургах хамтарсан сургалтыг зохион байгуулах.<br><br>Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, ялангуяа цахим орчинд хяналт тавих. | Сургалтад хамрагдсан цагдаа, прокурор, шүүгч тоо<br><br>Цахим орчинд гарсан гэмт хэргийн илрүүлэлтийн хувь | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Улсын ерөнхий прокурорын газар<br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Хууль зүйн үндэсний хүрээлэн<br><br>Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт судалгаа, мэдээллийн хүрээлэн<br><br>Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төв<br><br>Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн |
| 28. | 24(b) Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мөрдөн байцаалт, хянан шалгах, ял шийтгэлийн тоо бага байна | | | | | |
| 29. | 24(c) Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэрэгт жендэрийн мэдрэмжтэй мөрдөн байцаалт, хянан шалгах чиглэлээр шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг чадавхжуулах ажил хязгаарлагдмал байна. | | | | | |
| 30. | 24(d) Хохирогчийг дэмжих, нөхөн сэргээх хөтөлбөрийн талаар мэдээлэл хангалтгүй байна. | | | | | |
| 31. | 25(a) Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний төлөвлөгөө, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх. | 26. | Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, уг хуулийг дагаж гарсан зарим журмыг шинэчлэх, хэрэгжилтийг хангах. | Шинэчлэн боловсруулсан журмын тоо | Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 32. | 25(b) Эмэгтэйчүүд, охид, тэдний гэр бүлийн боловсрол, эдийн засгийн боломжийг өргөжүүлэх замаар хүний наймаачдын мөлжлөгт өртөмтгий байдлыг бууруулах зэрэг хүний наймааны үндсэн шалтгааныг арилгахад анхаарах. | 27. | Хүн худалдаалах гэмт хэрэг болон бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлого, арга хэмжээг сайжруулах. | Хүн худалдаалах гэмт хэрэгт болон бэлгийн мөлжлөгт өртсөн эмэгтэйчүүдийн тоо, тэдэнд үзүүлсэн үйлчилгээ, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 33. | 25(c) Хүн худалдаалах гэмт хэргийн бүх хэргийг шалгаж, ийм үйлдэлд оролцсон төрийн албан хаагч зэрэг | 28. | Хүн худалдаалах гэмт хэрэгт оролцсон төрийн албан хаагч, албан тушаалтанд Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, хэсэгт | Хариуцлага хүлээлгэсэн төрийн албан хаагчийн тоо | Хууль зүй, дотоод хэргийн яам | Шүүхийн ерөнхий зөвлөл<br><br>Улсын ерөнхий прокурорын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | буруутай этгээдүүдийг яллах, шийтгэхийг баталгаажуулах. | | зааснаар хариуцлага хүлээлгэсэн байх. | | | |
| 34. | 25(d) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, охидыг илрүүлэх, хамгаалах, зохих үйлчилгээ үзүүлэх шүүх, хууль сахиулагч, хилийн хяналтын байцаагч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах. | 29. | Уул уурхайн салбар хөгжиж буй аймгуудын хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон эсвэл болзошгүй эмэгтэйчүүд, охидыг олж илрүүлэх, хамгаалалтад авах, урьдчилан сэргийлэх, гэрч хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт үзүүлэх талаар шүүх, хууль сахиулагч, хилийн хяналтын байцаагч, прокурор, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах. | Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүдийн тоо<br><br>Хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хамгаалах чиглэлээрх сургалтад хамруулсан алба хаагчдын тоо | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба | Хууль зүй, дотоод хэргийн яам<br><br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Эрүүл мэндийн яам<br><br>Шүүхийн ерөнхий зөвлөл<br><br>Улсын ерөнхий прокурорын газар<br><br>Цагдаагийн ерөнхий газар<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 35. | 25(e) Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод зориулсан эмнэлгийн эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө, хууль зүйн туслалцааны хүртээмжийг хангалттай болгох. | | | | | |
| 36. | 25(f) Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах гэмт хэргийн мэдээллийг ангилан цуглуулж, бүс нутгийн бусад оронтой хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдээлэл солилцох, гэмт хэрэгтнүүдийг яллах үйл ажиллагааг зохицуулах зорилгоор хамтын ажиллагаагаа бэхжүүлэх. | | | | | |
| **Ес. Улс төр, нийгмийн амьдрал дахь тэгш оролцоо** | | | | | | |
| 37. | 27(a) Улс төрчид, Сонгуулийн Ерөнхий хорооны гишүүд, шүүгчид, хэвлэл мэдээллийн төлөөлөгчид болон олон нийтэд эмэгтэйчүүдийг улс төр, нийгмийн үйл хэрэгт эрчүүдтэй тэгш эрхтэй, чөлөөтэй, ардчилсан байдлаар, бүрэн оролцуулах тухай ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сурталчилгааны ажлыг зохион байгуулах нь конвенцыг бүрэн хэрэгжүүлэх, тогтвортой хөгжилд хүрэхэд анхаарах. | 30. | УИХ болон орон нутгийн сонгуульд өрсөлдөх эмэгтэй нэр дэвшигчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн намуудад уриалга гаргах, дэмжлэг үзүүлэх. | Эмэгтэй нэр дэвшигчид санхүүгийн дэмжлэг өгсөн намын тоо<br><br>УИХ болон орон нутгийн сонгуульд намуудаас нэр дэвшүүлсэн эмэгтэйчүүдийн тоо, нийт нэр дэвшигчдэд эзлэх хувь | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Улс төрийн намууд, түүний дэргэдэх эмэгтэйчүүдийн холбоод<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 38. | 27(b) Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, улс төрийн намуудын сонгуулийн нэрсийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдэд 40-аас доошгүй хувийн квот тогтоож, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, эмэгтэй нэр | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | дэвшигчдийг сургаж, компанит ажлыг нь санхүүжүүлж байгаа улс төрийн намуудад санхүүгийн урамшуулал олгох, эмэгтэй нэр дэвшигчдэд ихээхэн хүндрэл учруулж байгаа "Нэр дэвшигчийн татвар"-ыг арилгах. | | | | | |
| 39. | 27(c) Сонгуулийн квотыг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих үр дүнтэй механизмыг нэвтрүүлж, ялангуяа түүнд улс төрийн намууд дагаж мөрдөөгүй тохиолдолд шийтгэл ногдуулах асуудлыг тусгах. | 31. | Улс төрийн албан тушаалд эмэгтэйчүүдийг бэлтгэх анхан, дунд, ахисан түвшний хөтөлбөр хэрэгжүүлэх, удирдах албан тушаалд ажиллах эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх. | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан,<br><br>Удирдах албан тушаалд ажилладаг эмэгтэйчүүдийн тоо, өсөлтийн хувь | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Төрийн албаны зөвлөл<br><br>Улс төрийн намууд<br><br>Аж ахуйн нэгж байгууллага<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 40. | 27(d) Томилогдсон төрийн албан тушаал, түүний дотор засгийн газрын, Засаг дарга, дээд шатны шүүхийн албан тушаалуудад тэгш байдлыг хангаж, эмэгтэйчүүдийг төрийн албанд авах таатай боломжийг бүрдүүлэх. | | | | | |
| 41. | 27(e) Сонгуулийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн сонгох эрхийг хязгаарласан заалтыг цаг алдалгүй хүчингүй болгож, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас алагчлахыг хуулиар хориглосон болохыг баталгаажуулж, тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг хангах. | 32. | Сонсголын бэрхшээлтэй иргэдэд дохионы хэлээр сонгуулийн байранд, харааны бэрхшээлтэй иргэдэд дуут шуудангаар нэр дэвшигчийн мэдээлэл болон сонгуульд оролцох заавар, зөвлөгөө өгөх боломжоор хангах. | Сонгуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тоо | Сонгуулийн ерөнхий хороо | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Хэвлэл, мэдээллийн байгууллага<br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| **Арав. Боловсрол** | | | | | | |
| 42. | 28(a) Боловсролын түвшин, бага, дунд шатны боловсрол эзэмшиж буй охидын дундах сургууль завсардалт, ялангуяа эрт жирэмслэлт, сургууль дээрх бэлгийн дарамтаас шалтгаалж сургууль завсардсан талаарх мэдээлэл дутмаг, жирэмсэн охид, түүнчлэн залуу эхчүүд сургуульдаа эргэн элсэх боломж олгох бодлого байхгүй. | 33. | Сургуулийн орчинд охидыг дарамтлах, алагчлан гадуурхалтаас ангид байлгах, тэдний эрхийг нь хамгаалах, сургууль завсардсан охидыг боловсрол эзэмшихэд нь чиглэсэн тусгайлсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Дарамт, гадуурхалт, бэлгийн дарамтаас үүдэн сургууль завсардсан охидын тоо /өмнөх онтой харьцуулсан/ | Боловсрол, шинжлэх ухааны яам | Боловсролын ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн боловсролын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 43. | 28(b) Боловсролын байгууллага дахь охид, эмэгтэйчүүдийн бэлгийн дарамт, хүчирхийллийн тархалтын талаарх мэдээлэл хомс байгааг нэмэгдүүлэх. | 34. | ЕБС-ийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажлын байрны тодорхойлолтод охид, эмэгтэйчүүдийн бэлгийн дарамт, хүчирхийллийн тархалтын талаарх мэдээллийг цуглуулах, нууцлалыг нь хамгаалах, шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үйлчилгээнд холбон зуучлах үүргийг тусгах. | Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан эрх зүйн баримт бичиг /тушаал/ | Боловсрол, шинжлэх ухааны яам | Боловсролын ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн боловсролын газар<br>Нийслэлийн эрүүл мэндийн газар |
| 44. | 28(c) Шинжлэх ухаан, технологи, инженерчлэл математик гэх мэт салбарт охид, эмэгтэйчүүдийн төлөөлөл хангалтгүйгээс эдгээр салбаруудад ажиллах, карьераа хөгжүүлэх байдал нь хэвшээгүй байна.<br>29(c) Охид, эмэгтэйчүүд шинжлэх ухаан, технологи, инженерчлэл, математик зэрэг уламжлалт бус чиглэлээр боловсрол эзэмших, карьераа сонгохын ач холбогдлыг эцэг эх, багшлах боловсон хүчний мэдлэгийг дээшлүүлэх замаар эмэгтэй багш нарыг элсүүлэх, тэтгэлэг олгох, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх эмэгтэйчүүд, охидын анхаарлыг хандуулах, тогтвортой байдлыг урамшуулах схемийг нэвтрүүлж эдгээр салбарт охид, эмэгтэйчүүдийн тэгш хүртээмжийг хангах. | 35. | Шинжлэх ухаан, технологи, математик, инженерчлэл зэрэг салбарт мэргэжил сонгоход охидыг хандуулах зорилгоор эдгээр салбарт ажиллаж байгаа эцэг, эхчүүдээр дамжуулан ЕБС-ийн сурагчдын дунд мэргэжил сурталчлах, тэдгээр байгууллагатай танилцах аялал зохион байгуулах. | Шинжлэх ухаан, технологи, математик, инженерчлэл зэрэг салбарт мэргэжил сонгон суралцсан охидын хувь /өмнөх онтой харьцуулах/ | Боловсрол, шинжлэх ухааны яам | Боловсролын ерөнхий газар<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн боловсролын газар<br>Ерөнхий боловсролын сургуулиуд<br>Эцэг, эхчүүд |
| 45. | 29(a) Сургууль завсардсан тухай мэдээллийг хүйсээр ангилан цуглуулж, сургуулиас завсардсан охидыг сургуульд нь авч үлдэх арга хэмжээ авах, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд, хүүхэд төрүүлсэн залуу эхчүүд, бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидод эргэн элсэх бодлогыг хэрэгжүүлэх. | 36. | Сургууль завсардсан охид, эмэгтэйчүүдийг үргэлжлүүлэн сургах, сургуульдаа эргэн суралцах нөхцөл, боловсрол нөхөн олгох танхимын хөтөлбөрөөр болон цахим хэлбэрээр сурах боломжийг олгох. | Сургууль завсардсан охид, эмэгтэйчүүдээс үргэлжлүүлэн суралцагчийн тооны өсөлт /өмнөх онтой харьцуулах/ | Боловсрол, шинжлэх ухааны яам | Боловсролын ерөнхий газар<br>Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн боловсролын газар<br>Ерөнхий боловсролын сургуулиуд<br>Эцэг, эхчүүд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 46. | 29(b) Сургууль, сургуулийн дотуур байранд бэлгийн дарамт, хүчирхийллийн хэргийг мөрдөн, хянан шалгаж, хариуцлага хүлээлгэх, гэмт хэрэгтнүүдэд зохих шийтгэл ногдуулах, хохирогчдод нөхөн сэргээх арга хэмжээ авч байгааг баталгаажуулах, мөн түүнчлэн жендэрт суурилсан хүчирхийлэл, тэр дундаа бэлгийн хүчирхийлэлд өртсөн охидын тоог хүйсээр ангилж, хэргийн мөрдөн байцаалт болон ял шийтгэлийн түвшний талаарх мэдээллийг цуглуулах. | 37. | 1/Сургууль, дотуур байрны орчинд жендэрт суурилсан хүчирхийлэлд өртсөн хохирогчийн хэргийн мөрдөн байцаалт болон ял шийтгэлийн талаарх мэдээллийг хүйсээр ангилан цуглуулж, дүн шинжилгээ хийх.<br><br>2/Сургууль, дотуур байрны камержуулалтыг сайжруулах. | Хүйсээр ангилсан тоон мэдээлэл, дүн шинжилгээний тайлан<br><br>Камержсан сургууль, дотуур байрны тоо /өмнөх онтой харьцуулах/ | Боловсрол, шинжлэх ухааны яам | Боловсролын ерөнхий газар<br><br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн боловсролын газар<br><br>Ерөнхий боловсролын сургуулиуд |
| **Арван нэг. Хөдөлмөр эрхлэлт** | | | | | | |
| 47. | 30(a) Бүх салбарын цалин хөлсний жендэрийн зөрүү, хөдөлмөрийн зах зээл дэх босоо болон хэвтээ чиглэлийн ялгаа, албан болон албан бус салбарт эмэгтэйчүүд бага цалинтай ажилд голдуу төвлөрсөн байдал, хүүхэд харах үйлчилгээний хүртээмжтэй байдал хангалтгүй байна. | 38. | Сум орон нутгийн эмэгтэйчүүд болон зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүүхэд харах үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. | Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн хүүхдийн тоо, уг үйлчилгээг эрхэлж буй эмэгтэйчүүдийн тоо | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 48. | 30(b) Эмэгтэйчүүдийг хамгаалах нэрийн дор тэдэнд хориотой ажил мэргэжлийн жагсаалтад орсон хориглох бодитой үндэслэлгүй олон ажил мэргэжил, салбарт ялангуяа уул уурхайн салбарт, хөдөлмөр эрхлэх боломж хомс байгаа нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн боломжийг хязгаарлаж байна. | 39. | Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүнд үндэслэн уул уурхайн салбарт эмэгтэйчүүдийг ажиллуулах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр уул уурхайн компаниудтай хамтран ажиллах. | Уул уурхайн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийг өмнөх онтой харьцуулсан тооны өөрчлөлт | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 49. | 30(c) Эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах нас хэт эрт байгаа нь тэдний хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж, авах тэтгэврийн хэмжээг бууруулж байна.<br>31(d) Эмэгтэйчүүдийн тэтгэврийн насыг үе шаттайгаар нэмэгдүүлэх, үүнийг | 40. | Эмэгтэйчүүдийн өндөр насны тэтгэвэр тогтоолгох насыг нэмэгдүүлэх. | Нийгмийн даатгалын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Нийгмийн даатгалын ерөнхий газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эрэгтэйчүүдийн тэтгэврийн настай уялдуулах энэ тухайгаа эмэгтэйчүүдэд хангалттай ойлголт мэдээлэл өгөх. | | | | | |
| 50. | <u>30(e)</u> Хөдөлмөрийн хяналтын үндсэний тогтолцооны талаарх мэдээлэл дутмаг, түүний эрх мэдэл, чадавх, үр нөлөө нь хязгаарлагдмал байна. | 41. | 1/Хөдөлмөрийн хяналтын бүтэц, тогтолцоог боловсронгуй болгож, ОУХБ-ын 81, 129 дүгээр конвенцод нэгдсэн орох асуудлыг судлах.<br>2/Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг бүртгэх цахим мэдээллийнwww.om.insception.mn системийг шинээр хөгжүүлэх.<br>3/Шилэн хяналтын www.shilenkhyanalt.gov.mn цахим системд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эрсдэлийг шалгуур үзүүлэлтээр үнэлэн, эрсдэл өндөртэй салбарт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх. | Шилэн хяналтын www.shilenkhyanalt.gov.mn цахим системд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эрсдэлийг үнэлсэн арга хэмжээнд хамрагдсан байгууллагын тоо | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Аж ахуйн нэгж байгууллага |
| 51. | <u>31(a)</u> Жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийх, үнэлэх, ангилах аргаар бүх салбарын цалингийн хэмжээг судлах, судалгаа явуулж, цалингийн мэдээллийг хүйсээр ангилан нийтлэхийг ажил олгогчдод уриалж урамшуулах, жендэрийн цалингийн зөрүүг багасгаж арилгахын тулд ижил үнэ цэнэтэй ажилд ижил цалин олгох зарчмыг мөрдөх. | 42. | Бүх салбарын цалин, хөлсний тогтолцоонд жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийж, судалгаа явуулах, цалингийн зөрүүгийн уг шалтгааныг тогтоох, хариу арга хэмжээ авах. | Дүн шинжилгээний тайлан | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Ажил, олгогч эздийн нэгдсэн холбоо |
| 52. | <u>31(b)</u> Ажлын уян хатан зохицуулалтыг нэвтрүүлэх, хүүхэд харах үйлчилгээний хүртээмжтэй байлгаж, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх зэргээр хэвтээ ба босоо чиглэлд мэргэжлээр алагчлах явдлыг халж, Слон улсын хөдөлмөрийн байгууллагын 1981 оны Гэр бүлийн үүрэг хүлээгч ажилчдын тухай конвенцод (No156)-д нэгдэх асуудлыг анхааралдаа авах | 43. | Гэр бүлийн үүрэг хүлээгч ажилчдын тухай конвенцод нэгдэн орох асуудлыг судлах. | Конвенцод нэгдэн орох эсэхийг судалсан судалгааны үр дүнгийн тайлан | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Ажил, олгогч эздийн нэгдсэн холбоо |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 53. | 31(c) Хориглосон мэргэжил, салбарын жагсаалтыг халж, хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах замаар өмнө нь эмэгтэйчүүдэд хориглож байсан мэргэжлээр ажилд орохыг дэмжих, зохицуулалт хийх. | 44. | Эмэгтэйчүүдийг ажиллахыг хориглосон ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдлын үнэлгээ хийх. | Мэргэжлийн байгууллагын хяналтын дүгнэлт | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Ажил, олгогч эздийн нэгдсэн холбоо |
| 54. | 31(e) Ажлын байран дахь бэлгийн дарамтыг тусгайлан гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, ажил олгогч, ажилтнуудын бэлгийн дарамтын талаар болон Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих тухай хуулийн холбогдох заалтаар ойлголт өгөх, бэлгийн дарамтын талаарх бүх мэдээллийг сайтар шалгах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэмт хэргийн шинжтэй хариуцлага тооцох зохих шийтгэл ногдуулж, ОУХБ-ын 2019 оны (No190) Хүчирхийлэл, дарамтын тухай конвенцод нэгдэх асуудлыг авч үзэх. | 45. | ОУХБ-ын (No190) Хүчирхийлэл, дарамтын тухай конвенцод Монгол улс нэгдэх асуудлыг судалж, дүгнэлт гаргах. | Конвенцод нэгдэн орох асуудлыг судалсан судалгааны дүгнэлт | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо<br><br>Ажил, олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 55. | 31(f) Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн нөхцөлийг үр дүнтэй хянахын тулд хөдөлмөрийн хяналтын үндэсний тогтолцооны чанар, чадавхыг бэхжүүлэх, эмэгтэйчүүдийг алагчлах хандлага болон үйлдэл гаргаж буй ажил олгогчдыг зохих ёсоор шийтгэх, эрхзүйн шударга байдлыг эмэгтэй ажилчдад хүртээмжтэйгээр нэмэгдүүлэх. | 46. | Эмэгтэйчүүдийн ажиллах нөхцөлийг сайжруулах, ажлын байран дээр алагчилахын эсрэг нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх, ажил олгогчдыг тогтмол сургах. | Эмэгтэйчүүдийн ажлын байран дээр алагчилахын эсрэг нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | | |
| **Арван хоёр. Эрүүл мэнд** | | | | | | |
| 56. | 32(a) Эх болон нярайн эндэгдэл бага зэрэг буурсан боловч 2018 онд 100 мянган амьд төрөлтөд 27.1, 1000 амьд төрөлтөд 8.7 тус тус байгаа нь харьцангуй өндөр байна. | 47. | Жирэмсний эрт үеийн хяналтад ороогүй, эрхтэн тогтолцооны эмгэг суурь өвчтэй, хоол тэжээлийн дутагдалтай, цус багадалтай, эмзэг бүлгийн эхчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хяналт, ялангуяа жирэмсэн | Жирэмсний эрт үеийн хяналтад орсон эмзэг бүлгийн эхчүүдийн тоо /өмнөх онтой харьцуулах/ | Эрүүл мэндийн яам | Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эхийн хяналтын чанарыг сайжруулах. | | | |
| 57. | 32(b) Орчин үеийн, өргөн боломжийн жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хүртээмж, ялангуяа хөдөө орон нутагт хангалтгүй байна.<br>33(b) Сайтар бэлтгэгдсэн боловсон хүчин бүхий эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний байгууллагуудыг ялангуяа хөдөө, алслагдсан орон нутагт эмэгтэйчүүд, охидын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, бүх эмэгтэйчүүд, охид, тэр дундаа хөдөө орон нутагт жирэмслэхээс хамгаалах орчин үеийн арга хэрэгслийг хүртээмжтэй болгох. | 48. | Жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслээр хангахад зориулсан зардлыг улсын төсөвт үе шаттай нэмэгдүүлэх, хөдөө, орон нутгийн хүртээмжийг нэмэгдүүлэх. | Хөдөө, орон нутагт жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ | Эрүүл мэндийн яам | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 57. | 32(c) Өсвөр насны охид бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэл авахад саад бэрхшээлтэй тулгарч байна. | 49. | Өсвөр үеийнхний дунд бэлгийн болон нөхөн үржихүйн чиглэлээр үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, тэднээр дамжуулан мэдээллийг өсвөр үеийнхэнд хүргэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх. | Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, мэдээлэл авсан өсвөр насныхны тоо, хүйсээр | Эрүүл мэндийн яам | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар<br>Олон улсын байгууллага<br>Төрийн бус байгууллага |
| 58. | 32(d) Сүүлийн үед буурч байгаа хэдий ч өсвөр насныхан, тэр дундаа охидын дунд амиа хорлох явдал өндөр байна. | 50. | Ерөнхий боловсролын сургуульд мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч ажиллуулах замаар өсвөр үеийнхэн, хүүхдүүд зөвлөгөө, мэдээлэл, тусламж авах боломжийг нэмэгдүүлэх. | Зөвлөгөө, мэдээлэл, тусламж авсан өсвөр насныхны тоо, хүйсээр, тооны өсөлт /өмнөх оны мэн үетэй харьцуулснаар/ | Боловсрол, шинжлэх ухааны яам | Эрүүл мэндийн яам<br>Боловсролын ерөнхий газар<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Ерөнхий боловсролын сургууль |
| 59. | 32(e) Умайн хорт хавдрын үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь маш бага, хөхний хорт хавдартай тохиолдлын талаарх улсын хэмжээний мэдээлэл | 51. | Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний хорт хавдраас сэргийлэх зорилгоор урьдчилан | Умайн хүзүүний хорт хавдрын талаар мэдээлэл авч, үзлэгт | Эрүүл мэндийн яам | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хомс, хорт хавдрын эмчилгээний талаар мэдээлэл охид, эмэгтэйчүүдэд дутмаг байна. | | сэргийлэх үзлэгт орохын ач холбогдлыг хэвлэл, мэдээллийн сувгуудаар таниулах. | хамрагдсан охид, эмэгтэйчүүдийн тоо /өмнөх оны мөн үетэй харьцуулснаар/ | | Эрүүл мэндийн хөгжлийн төв<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар<br>Олон улсын байгууллага<br>Төрийн бус байгууллага |
| 60. | 32(f) Агаарын бохирдол нь зонхилон тохиолддог таван өвчний хоёр болох амьсгалын замын болон зүрх судасны өвчинтэй холбоотой нас баралтын тэргүүлэх шалтгаан болж байгаа бөгөөд амьгүй төрөлт, дутуу төрөлтийн суурь шалтгаан байх магадлалтай | 52. | Дотоод орчны агаарын стандартыг шинэчлэн боловсруулах, 1 хүртэлх насны хүүхдийн пневмококкийн эсрэг дархлаажуулалтад бүрэн хамруулах, дотоод орчны агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд анхааруулга, мэдээллийг мэдээллийн бүх хэлбэрээр хүргэх. | Пневмококкийн эсрэг дархлаажуулалтад хамрагдсан 1 хүртэлх насны хүүхдийн тоо | Эрүүл мэндийн яам | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Эрүүл мэндийн хөгжлийн төв<br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар<br><br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 61. | 32(d) Эрүүл мэндийн тогтолцоонд лесби, бисексуал, трансжендэр, интерсекс эмэгтэйчүүдийг алагчлахын эсрэг эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, ойлголт дутмаг байна.<br>33(c) Лесби, бисексуал, трансжендер, интерсекс эмэгтэйчүүдэд тулгардаг бие махбод болон сэтгэл зүйн эрүүл мэндийн асуудал, тэдэнд тулгардаг ялгаварлан гадуурхалт, гутаан доромжлолын талаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагын талаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд эрх тэгш байх, ялгаварлан гадуурхахгүйгээр хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэхэд эрүүл мэндийн салбарыг бэлтгэх. | 53. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчлүүлэгчид ээлтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид орчин бүрдүүлэх чиглэлээр эмнэлгийн байгууллагын ажилтныг үе шаттай бэлтгэх, сургах. | Үйлчлүүлэгчид ээлтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид орчин бүрдүүлсэн эсэхэд хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайлан | Эрүүл мэндийн яам | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв<br><br>Эрүүл мэндийн хөгжлийн төв<br><br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар<br><br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 62. | 33(a) Эх, нялхсын эндэгдлийн шалтгааныг анхаарч, эх барихын тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох, мэргэжлийн ур чадвартай эх баригчдын | 54. | Алслагдмал орон нутагт мэргэжлийн ур чадвартай эх баригчийн тоог нэмэгдүүлэх, тэдний нийгмийн баталгааг | Алслагдмал орон нутагт мэргэжлийн ур чадвартай эх баригчийн тоог нэмэгдүүлэх | Эрүүл мэндийн яам | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тоог хөдөө, алслагдмал орсн нутагт нэмэгдүүлэх. | | сайжруулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэр | | Аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газар |
| 63. | 33(c) Амиа хорлолтын үндсэн шалтгааныг тогтоох судалгаа хийх, залуу эмэгтэйчүүд, охидын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг шийдвэрлэх арга хэмжээ авах, тэдэнд зохих дэмжлэг үзүүлэхийн тулд хангалттай нөөцийг хуваарилах. | 55. | Залуучууд, өсвөр үеийнхний дундах амиа хорлолтын үндсэн шалтгааныг тогтоох судалгаа хийх, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр тодорхой арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх. | Амиа хорлолтын талаар хийгдсэн судалгааны тайлан, үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Эрүүл мэндийн яам | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br>Боловсролын ерөнхий газар<br>Насан туршийн боловсролын үндэсний төв |
| 64. | 33(d) Умайн хүзүүний хорт хавдартай тэмцэх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө баталж, болзошгүй бүх эмэгтэйчүүдийг хамруулж, хөхний хорт хавдрын тохиолдлын талаарх мэдээллийг ангилан цуглуулж, эмнэлгийн болон эрүүл мэндийн мэргэжилтнүүдэд тэр дундаа хөдөө орон нутгийн мэргэжилтнүүдэд эдгээр өвчнийг эрт илрүүлэх сургалт явуулах. | 56. | Умайн хүзүүний хорт хавдартай тэмцэх үндэсний хэмжээнд төлөвлөгөө боловсруулах, эрт илрүүлэлт орчин үеийн шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх. | Умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, өвчлөлийн тоо /өмнөх оны мөн үетэй харьцуулах/ | Эрүүл мэндийн яам | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар<br><br>Хавдар Судлалын Үндэсний Төв<br><br>Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар |
| **Арван гурав. Эдийн засгийн эрх мэдэл** | | | | | | |
| 65. | 35(a) Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх үе шат бүрд эмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн байгууллага, сүлжээдийг оролцуулж байх. | 57. | Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэх үе шат бүрд эмэгтэйчүүдийн чиглэлээр ажилладаг ТББайгууллага, Иргэний нийгмийн байгууллагыг оролцуулах, хамтран ажиллах. | Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг сайжруулах үндэсний арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим<br>Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 66. | 35(b) Орлого олох боломж, санхүүгийн зээл, тэр дундаа барьцаа хөрөнгөгүй бага хүүтэй зээл авах боломжийг зохицуулах замаар эмэгтэйчүүд бизнес эрхлэхэд хангалттай дэмжлэг үзүүлэх. | 58. | Эмэгтэйчүүд бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлж буй банк, санхүүгийн байгууллагын сайн туршлагыг нэвтрүүлэх, түгээн дэлгэрүүлэх. | Эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжиж байгаа банк, санхүүгийн байгууллагын эмэгтэйчүүдэд зориулсан багц арга хэмжээний тайлан, зээлд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо, тооны өсөлт /өмнөх онтой харьцуулах/ | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим<br><br>Монголын Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 67. | 35(c) Хүүхэд харах газар гэх мэт дэд бүтэц, нийгмийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийх замаар эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийг үнэлж, тэдгээрийг бууруулах, дахин хуваарилах арга хэмжээ авах. | 59. | Хүүхэд харах үйлчилгээг олон төрөлтэй болгох замаар эмэгтэйчүүдийн хөлсгүй хөдөлмөрийг бууруулах арга хэмжээ авах. | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн тайлан, хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй эмэгтэйчүүдийн тоо | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар<br><br>Аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтэс |
| 68. | 35(d) Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, цалинтай чөлөө, жирэмсний болон амаржсаны амралт зэрэг хөдөлмөрийн хууль тогтоомж, нийгмийн хамгааллын хамрах хүрээг тэлж албан бус эдийн засагт үйл ажиллагаа явуулж байгаа болон хувиараа хөдөлмөр эрхлэгч эмэгтэйчүүдийг хамруулах. | 60. | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчин, нөхөрлөл, хоршооны гишүүн, албан бус эдийн засагт ажиллаж байгаа ажилтны хүний эрх, суурь зарчмыг хэрэгжүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн хамтын хэлэлцээрт тусгаж, хэрэгжүүлэх. | Хамтын хэлэлцээрт тусгагдсан асуудлын тоо, хэлэлцээрийн биелэлтийн тайлан | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br>Монголын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбоо<br>Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо |
| **Арван дөрөв. Хөдөөгийн эмэгтэйчүүд** | | | | | | |
| 69. | 36(a) Хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүдийн газар өмчлөх, ашиглах эрх, түүнчлэн шударга ёс, боловсрол, эрүүл мэнд, орон сууц, ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламж, албан хөдөлмөр, ур чадвар хөгжүүлэх сургалт, орлого нэмэгдүүлэх, бичил зээл авах боломж хязгаарлагдмал байсаар байна. | 61. | Бичил бизнес эрхлэгчдэд хүүгийн хөнгөлөлттэй жижиг зээл олгох, зээл авсан иргэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт, санхүүгийн бүртгэл, маркетинг, менежмент, борлуулалтын чиглэлээрх сургалт болон бизнесийн зөвлөн туслах үйлчилгээнд хөдөөгийн | Жижиг бизнесийн хөтөлбөрт хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо,<br>Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр зээлд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо | Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам | Хүнс, хөдөө аж ахуйн яам<br><br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хамруулах. | | | |
| 70. | 36(b) Олон нийтийн хүрээнд шийдвэр гаргах үйл явцад хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүдийн оролцоо бага байгааг нэмэгдүүлэх.<br><br>37(d) Байгалийн нөөцийн менежментийн төлөвлөлт, шийдвэр гаргалтад хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүдийн үр дүнтэй оролцоог хангах. | 62. | Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн оролцоог хангах. | Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт хийх явцад оролцсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь /өмнөх онтой харьцуулах/ | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Эдийн засгийн хөгжлийн яам<br><br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Сангийн яам<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 71. | 36(c) Уул уурхайн үйлдвэрлэлд бохирдсон гол мөрөн худгийн усыг ашигласнаар эмэгтэй, эрэгтэй, охид, хөвгүүдэд үзүүлэх нөлөөлөл, үр дагаврыг тодорхойлох жендэрийн дүн шинжилгээ хийх. | 63. | Байгаль орчин, хүний эрх, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнгийн мэдээллийг олон нийтэд түгээх, энэ төрлийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах. | Байгаль орчин, хүний эрх, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн жендэрийн мэдрэмжтэй үнэлгээ хийсэн тайлан | Байгаль, орчин аялал жуулчлалын яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| 72. | 37(a) Хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүдийн газар өмчлөх, эзэмших эрхийн ач холбогдлын талаар болон жендэр болон өмчтэй холбоотой уламжлалт хандлагын хор уршгийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх. | 64. | Эмэгтэйчүүдийн газар өмчлөх, эзэмших байдалд жендэрийн шинжилгээ хийж, үр дүнг бодлого, үйл ажиллагаанд тусгах. | Эмэгтэйчүүдийн газар өмчлөх, эзэмших байдалд хийсэн жендэрийн шинжилгээний тайлан | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br>Аймаг, нийслэлийн Газар зохион байгуулалтын алба<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 73. | 37(e) Бэлчээрийн менежмент, газрын баялагтай холбоотой тоног төхөөрөмж, малын тэжээл, эрчим хүч, зах зээл, маркетингийн үйлчилгээг сайжруулах техникийн дэмжлэг, сургалтаас гадна технологийн болон зохих үйлчилгээг өргөжүүлж, хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдэд хүртээмжтэй болгох зохицуулалт хийх. | 65. | Малчин эмэгтэйчүүдэд бүлэг бүрдүүлэх, хоршоо байгуулах талаар техникийн зөвлөгөө өгөх. | Бүлэг, хоршоонд хамрагдсан нийт малчдын тоо, хүйсээр | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 74. | 37(c) Хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүдийн бага хүүтэй зээл болон бусад төрлийн санхүүгийн зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх. | 66. | Цөөн малтай болон малгүй эмэгтэйчүүдийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр малжуулах, санхүүгийн дэмжлэг олгох. | Малжуулах арга хэмжээнд хамрагдсан нийт малчдын тоо хүйсээр | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 75. | 37(e) Уул уурхайн салбарын үйл ажиллагааны нийгэм, эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг бие даасан байгууллагаар гүйцэтгүүлж, жендэрийн мэдрэмжтэй, үр дүнг хэвлэн нийтлэх | 67. | Байгаль орчин, хүний эрх, нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээг жендэрийн мэдрэмжтэй хийх аргачлал боловсруулах. | Жендэрийн мэдрэмжтэй аргачлал | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 76. | 37(f) Уул уурхайн болон хамаарал бүхий компаниудаас орон нутгийн иргэд, тэр дундаа хөдөөгийн эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьжиргаанд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх стандартыг боловсруулж хэрэгжүүлэх. | 68. | Уул уурхайгаас орсон орлогоос иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, сөрөг нөлөөлөлд өртсөн нутгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх. | Иргэдийн эрүүл мэндэд зарцуулсан төсөв, /сая.төг/ | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | Эрүүл мэндийн яам<br><br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар |
| 77. | 37(g) Химийн бодис болон бусад аюултай материалын хоруу чанар, хүн, малын эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөллийн талаар нийгмийн эрүүл мэндийн сэрэмжлүүлэг, мэдээллийн үйлчилгээг бий болгож, хөдөө, орон нутгийн болон малчин эмэгтэйчүүдэд таниулах. | 69. | Химийн бодис болон бусад аюултай материалын хоруу чанарын талаар иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Олон нийтийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Эрүүл мэндийн яам | Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам<br>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв<br>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br>Хэвлэл, мэдээллийн байгууллага |
| **Арван тав. Уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг бууруулах** | | | | | | |
| 73. | 38. Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн эрсдэлийг даван туулах эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх төслөөр гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх зэрэг гамшгийн эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлого, эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийснийг хорооны зүгээс сайшааж байна. Гэвч байгаль орчны эрсдэл, сорилт, уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн | 70. | Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны суурь баримт бичигтэй уялдуулсан гамшгийн эрсдэлийг бууруулах жендэрийн мэдрэмжтэй үндэсний стратегийг зорилтот бүлэг, эмэгтэйчүүд, ЛГБТИК+ зэрэг иргэдийн оролцоотой хэлэлцэн, боловсруулж батлах, | Зорилтот бүлгийн эмэгтэйчүүд, ЛГБТИК+ иргэдийн оролцоотой хэлэлцэн, боловсруулж батлуулсан Үндэсний стратегийн хэрэгжилтийн тайлан | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Онцгой байдлын ерөнхий газар<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | эрсдэлийг бууруулахад жендэрийн мэдрэмжтэй үндэсний стратеги байхгүйд санаа зовниж байна. | | хэрэгжүүлэхдээ түншлэлийг хангах. | | | |
| 79. | <u>39.</u> Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд гамшгийн эрсдэлийг бууруулах жендэртэй холбоотой хэмжүүрүүдийн тухай 37 (2018) дугаар ерөнхий зөвлөмжийн дагуу уур амьсгалын өөрчлөлт, гамшгийн хариу арга хэмжээ, гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөрүүд, хууль тогтоомж, бодлого боловсруулахад эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог хангахыг Хорооны зүгээс зөвлөж байна. Мөн тэдгээр төлөвлөгөө, бодлогыг боловсруулахад жендэрийн асуудлыг тусгах, эмэгтэйчүүд, гэр дундаа хөдөө орон нутгийн эмэгтэйчүүдтэй хэлэлцэж, тэдний санаа бодлыг тусгах нь зүйтэй. Түүнчлэн цаг уурын өөрчлөлт нь эмэгтэйчүүдийн нөөц ба амьжиргаанд тэгш бусаар нөлөөлөхийн эсрэг арга хэмжээ авахыг тус улсад зөвлөж байна | 71. | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулах, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд дасан зохицох асуудлаар эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, бодлого, төлөвлөлтөд тусгах. | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд оролцсон эмэгтэйчүүдийн хувь /нийт эмэгтэйчүүдийн тоотой харьцуулах/ | Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар<br><br>Байгаль, орчин аялал жуулчлалын газар<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| **Арван зургаа. Нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүд** | | | | | | |
| 80. | <u>41.</u> Хорооны зүгээс хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охид, лесби, бисексуал, трансжендер болон интерсекс эмэгтэйчүүд, ядуу эмэгтэйчүүд, өрх толгойлсон эхчүүд, өндөр настай эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаар, тэдний улс төр, нийгмийн амьдрал, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, түүний дотор бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломж, түүнчлэн тэдэнд тулгарч буй алагчилал, жендэрт суурилсан хүчирхийллийн хэлбэрүүдийн талаар | 72. | Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаар, тэдний улс төр, нийгмийн амьдрал, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, тэдэнд тулгарч буй гадуурхал, жендэрт суурилсан хүчирхийллийн талаар мэдээлэл цуглуулж, жендэрийн судалгааг хөгжүүлэх. | Нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн талаарх хийсэн жендэрийн судалгааны тайлан, тайланд үндэслэн төлөвлөсөн арга хэмжээний тайлан | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Үндэсний статистикийн хороо<br><br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | улсын хэмжээнд мэдээлэл цуглуулахыг зөвлөж байна. | | | | | |
| **Арван ес. Гэрлэлт ба гэр бүлийн харилцаа** | | | | | | |
| 81. | 43:a). Гэрлэлт, гэр бүлийн харилцаа, түүнийг цуцлахаас үүсэх эдийн засгийн үр дагаврын тухай Хорооны 2013 оны 29 дугаар ерөнхий зөвлөмжийн дагуу гэрлэлт цуцлахад эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх, тэр дундаа гэр бүл салахад гэр бүлийн дундын хөрөнгийг тэгш хуваарилах нөхцөлийг бүрдүүлэх. | 73. | Гэрлэлт цуцлахад эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эрхтэй байх, гэр бүлийн дундын хөрөнгийг тэгш хуваарилах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах. | Батлагдсан хуулийн төсөл | Хууль зүй дотоод хэргийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам |
| 82. | 43:b). Гэрлэлтийг цуцалсан тохиолдолд гэрлэгсдийн хооронд гэр бүлийн өмч, аж ахуйн нэгжийг хуваах, гэрлэлт цуцалсны дараа хүүхдийн тэтгэмж тогтоолгох, хүүхдэд үзүүлэх дэмжлэгтэй холбоотой хууль тогтоомж, холбогдох шүүхийн тохиолдлын талаар мэдээлэл цуглуулах. | 74. | Гэрлэлт цуцалсны дараа гэрлэгсдийн өмч, аж ахуйн нэгжийг хуваах, хүүхдийн тэтгэмж тогтоолгох, хүүхдэд үзүүлэх дэмжлэгтэй холбоотой тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, зохицуулалтыг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах. | Дүн шинжилгээний тайлан, батлагдсан хуулийн төсөл | Хууль зүй дотоод хэргийн яам | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br><br>Шүүхийн Ерөнхий зөвлөл<br><br>Хууль зүйн Үндэсний хүрээлэн |
| **Хорь. Өгөгдөл цуглуулах** | | | | | | |
| 83. | 45. Жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд хүний эрхээ эдлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийн үр дүн, нөлөөг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг хүйс болон бусад холбогдох хүчин зүйлээр нь ангилан цуглуулах ажлыг сайжруулахын тулд жендэрийн шалгуур үзүүлэлтийн тогтолцоог хөгжүүлэхийг тус улсад уриалж байна. Үүнтэй холбогдуулан Хороо эмэгтэйчүүдийн нөхцөл байдлын талаарх статистикийн мэдээллийн тухай (1989) дугаар ерөнхий зөвлөмжид тус улс анхаарлаа хандуулж, үнэн зөв мэдээлэл цуглуулахад туслах НҮБ-ын холбогдох байгууллагуудаас техникийн туслалцаа авч, эмэгтэйчүүдийн байгууллага, | 75. | Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэхэд төрийн болон эрдэм шинжилгээний байгууллага, бусад иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах. | Жендэрийн мэдрэмжтэй бодлого, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт, хүйсээр ангилсан мэдээлэл цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Үндэсний статистикийн хороо<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | холбоодтой хамтын ажиллагаагаа сайжруулахыг зөвлөж байна. | | | | | |
| **Хорин нэг. Бээжингийн тунхаглал, Үйл ажиллагааны хөтөлбөр** | | | | | | |
| 84. | 46. Хорооны зүгээс эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдлыг бодитой болгохын тулд Бээжингийн тунхаглал, мөрийн хөтөлбөрийг ашиглах, мөн конвенцид тусгагдсан эрхийн хэрэгжилт болон дээрх тунхаглал, хөтөлбөрийн 25 жилийн хэрэгжилтийн бодит байдлыг үнэлэх үнэлгээ хийхийг зөвлөж байна. | 76. | Бээжингийн тунхаглал, үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, Ерөнхий ассамблейн 23 дугаар ээлжит бус чуулганы үр дүн болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, Тогтвортой хөгжлийн зорилт 2030 мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэн, гарсан ахиц, дэвшил, тулгарч буй сорилтуудын талаар үндэсний хэмжээнд тайланг бэлтгэх. | Үндэсний тайлан | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба | Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Төрийн бус байгууллага<br><br>Олон улсын байгууллага |
| **Хорин хоёр. Түгээн дэлгэрүүлэх** | | | | | | |
| 85. | 47. Энэхүү эцсийн ажиглалт, дүгнэлтийг албан ёсны хэлээр бүх түвшний (үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн) холбогдох төрийн байгууллагуудад, ялангуяа Засгийн газар, яамд, парламент, шүүх эрх мэдлийн байгууллагад цаг алдалгүй хүргэж, бүрэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх. | 77. | Монгол улсын 10 дахь тайланд Хорооны зүгээс өгсөн зөвлөмж, дүгнэлтийг төрийн бүхий л байгууллагуудад мэдээлж, хэрэгжилтэд талуудын оролцоог өргөжүүлэх. | Нөлөөллийн арга хэмжээний тоо, тайлан | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Жендэрийн салбар зөвлөл, хороод |
| 86. | 48. Конвенцын хэрэгжилтийг хөгжлийн хүчин чармайлттай уялдуулж, түүнд бүс нутгийн болон олон улсын техникийн туслалцааг ашиглахыг хорооны зүгээс зөвлөж байна. | 78. | Конвенцын агуулгыг салбаруудын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгах, шаардлагатай тохиолдолд олон улсын техникийн туслалцаа авах хүсэлт гаргах. | НҮБ-ын ЭАБХУТКонвенцын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд тусгахад дэмжлэг үзүүлсэн санхүүжилтийн хэмжээ /сая.төг/ | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Төрийн бус байгууллага |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Олон улсын байгууллага |
| **Хорин дөрөв. Бусад гэрээнд нэгдэх** | | | | | | |
| 87. | 49. Монгол улс олон улсын хүний эрхийн есөн гол баримт бичгийг дагаж мөрдөх нь эмэгтэйчүүд амьдралдаа хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө эдлэх боломжийг нааштайгаар нэмэгдүүлнэ гэж хорооны зүгээс тэмдэглэж байна. Тиймээс тус улсыг Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцод нэгдэн орохыг зөвлөж байна | 79. | Цагаач ажилчид болон тэдний гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын конвенцод нэгдэх асуудлыг судалж, дүн шинжилгээ гаргах. | Конвенцод нэгдэх асуудлыг судалсан дүн шинжилгээний тайлан, дүгнэлт | Гадаад харилцааны яам | Гадаад харилцааны яам<br><br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br><br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br><br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 88. | 50. Хорооны зүгээс 23 (a) ба (d), 27 (a), 29 (c) дугаар хэсэгт тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хоёр жилийн дотор бичгээр мэдээлэл ирүүлэхийг оролцогч улсаас хүсэж байна. | 80. | Конвенцын 23 (a) ба (d), 27 (a), 29 (c) дүгээр хэсэгт тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тайланг Хороонд хүргүүлэх. | Хороонд хүргүүлсэн мэдээлэл | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| **Хорин тав. Дараагийн ээлжит тайлан бэлтгэх** | | | | | | |
| 89. | 51. Хорооны зүгээс оролцогч улсыг 2026 оны 07-р сард багтаан 11 дэх удаагийн тайлангаа ирүүлэхийг урьж байна. Тайланг хугацаанд нь өгөхөөс гадна тайланг хүлээлгэн өгөх өдөр хүртэлх хугацааг хамруулбал зохино. | 81. | Монгол Улсын 11 дэх тайланг салбарын байгууллагуудын оролцоотой боловсруулан Хороонд хүргүүлэх, | Хороонд хүргүүлсэн тайлан | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |
| 90. | 52. Хороо оролцогч улсыг хүний эрхийн олон улсын гэрээний дагуу тайлагнах тусгай удирдамж, ялангуяа үндсэн баримт бичиг болон гэрээний тусгай баримт бичгийг боловсруулах тусгай удирдамжийг (HRI/GEN/2/Rev.6, I бүлэг) мөрдлөг болгохыг хүсэж байна. | 82. | Монгол Улсын Засгийн газрын ээлжит 11 дэх тайланг удирдамжийн дагуу боловсруулах. | Хороонд хүргүүлсэн тайлан | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Гадаад харилцааны яам<br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба<br>Жендэрийн салбар зөвлөл, хороод<br>Төрийн бус байгууллага<br>Олон улсын байгууллага |